

# Тун хэтрүүлэхээс сэргийлэхийн тулд фентанилын тестийн стрипийг хэрхэн хэрэглэх вэ



**\*\*Тестийн стрип бүх хэлбэрийн фентанилыг илрүүлэх баталгаагүй. Таны эмийн найрлагад фентанил байхгүй гэж бичсэн байсан ч та хэтрүүлэн хэрэглэж болзошгүй**

Фентанил хэмээх үхлийн аюултай **опиоид** бодисыг **героин, кокаин, шахмал эм** зэрэгт нэмдэг.

Фентанилын тестийн стрип таны эмэнд фентанил агуулгдсан эсэхийг илрүүлнэ. Та тун хэтрүүлэхээс сэргийлэхийн тулд фентанил тестийн стрип ашиглах эдгээр алхмуудыг дагаж мөрдөж болно.

## Алхам 1 - Ус нэмэх

Үлдэгдэл шалгах



Тариан дээрээ буцалгагчаасаа 10 дусал ариутгасан ус нэмээд сайтар хутга.

Шахмал эм эсвэл нунтаг шалгах



Хоосон савны үлдэгдэл дээр нь ус нэмээд сайтар хольж хутга. Хэрэв та шахмал эм хэрэглэдэг бол жижиглээд усанд хийж, хутга.

## Алхам 2 - Тест хийх



Тестийн стрипийнхээ хөх үзүүрээс барьж, усанд 15 секунд дүрнэ үү. Та зөвхөн долгионтой шугам хүртэл дүрэхээ мартуузай.

## Алхам 3 - Хүлээх



Дунд хэсэгт зураас гарч ирэх хүртэл хоёр минут хүлээнэ үү.

## Алхам 4 - Хариу харах



1 зураас - Фентанил агуулсан!



2 зураас - Болгоомжтой хэрэглэнэ үү

**Тестийн хариу гарсны дараа би юу хийх боломжтой вэ?**

1. Налоксоныг хавсран хэрэглэж болно
2. Хэрэв би хэтрүүлэн хэрэглэвэл 911 рүү залгаж, надад налоксин өгөх хүнтэй хамт байх хэрэгтэй
3. Би удаан хөдөлж, бага хэрэглэж болно

**\*\*Эдгээр зааврыг ашиглахыг зөвшөөрсөн PreventOverdoseRI.org байгууллагад баярлалаа**

**\*\*Фентанилын тестийн стрип хэрэглэн шалгасан боловч ямар ч эм аюулгүй байдаггүй гэдгийг санаарай. Арлингтон Тойрог тус тойргоос олгосон түргэвчилсэн тестийн стрип хэрэглэн шалгасан аливаа мансууруулах бодисыг хэрэглэснээс шалтгаалан гэмтсэн, нас барсан, хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдлууд, учирсан бусад хор хөнөөл, хохиролд хариуцлага хүлээхгүй**

# Хор хөнөөл бууруулах ЗӨВЛӨМЖҮҮД

Удаан хэрэглэж, бага хэрэглээрэй. Фентанил (героинтой харьцуулахад) бага зэрэг удаан үйлчилдэг бөгөөд заримдаа богино хугацаанд, тарьж дуусаагүй байхад тун хэтрэх тохиолдол байдаг.

Тарихын оронд хамраараа сорох эсвэл тамхи байдлаар татахыг оролдоно уу. Тарилга нь тунг хэтрүүлэх хамгийн өндөр эрсдэлтэй тул хамраараа сорох эсвэл тамхи байдлаар татах нь эрсдэл бууруулахад тусална. **Тамхи байдлаар татах эсвэл хамраараа сорж хэрэглэх тохиолдолд ялангуяа фентанил агуулсан бол тун хэтрүүлэх эрсдэлтэй тул бага тунгаар хэрэглэж эхэлнэ үү.**

Тун хооронд зайтай хэрэглэнэ үү. Тун, хүлцэх хязгаар зэргээс шалтгаалан фентанилын үйлчлэл хүн бүрт өөр байдаг тул тунг хоорондын хугацаа зохицуулна уу.

Ганцаараа хэрэглэхдээ болгоомжтой байгаарай. Бид хамтдаа илүү аюулгүй боловч итгэдэг найзтайгаа үргэлж хамт байх боломжгүй байдаг. Хэрэв та ганцаараа байхдаа хэрэглэх шаардлагатай бол таньдаг хэн нэгнээс таныг шалгаж үзэхийг хүсээрэй, ингэснээр тун хэтрүүлсэн тохиолдолд танд туслах боломжтой.

Бүлэгт үү? Хэрэглээгээ шалгана уу. Үргэлж сонор сэрэмжтэй байж, багадаа нэг хүн налоксон хадгалж байгаа эсэхийг шалгаарай.

**Налоксон/НАРКАН эмийг үргэлж биедээ авч явж байгаарай.** Тун хэтрүүлсэн шинж тэмдгүүдийн талаар мэдэж аваад, налоксон хэрэглэхэд бэлэн байгаарай. Налоксон үнэ төлбөргүй авахыг хүсвэл [narcan@arlingtonva.us](mailto:narcan@arlingtonva.us) хаягаар хүсэлт гаргах эсвэл эмийн сангаас жоргүй худалдаж аваарай.

Биеийн байдлаа ажигла. Тун хэтрүүлэн хэрэглэх нь эрүүл мэндийн ерөнхий байдалд нөлөөлдөг. Аль болох шингэн зүйл ууж, идэж, амрах хэрэгтэй.

**Тестийн стрип эсвэл үнэ төлбөргүй НАРКАН  
НЭМЖ АВАХЫГ ХҮСВЭЛ:  
571-302-0327 | [narcan@arlingtonva.us](mailto:narcan@arlingtonva.us)**